

САЛБАР ХООРОНДЫН ХАМТАРСАН ТАНДАЛТ СУДАЛГАА ЗОХИОН БАЙГУУЛАВ

2025

ОН



Зоонозын өвчин судлалын үндэсний төв, Улсын мал эмнэлгийн ариун цэврийн төв лабораторийн мэргэжилтнүүд “Анзаарагддаггүй өвчний” хамтарсан тандалт судалгааны ажлыг 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдрөөс 10 дугаар сарын 30-ны өдрийг дуустал Төвийн бүсийн Булган, Дархан-Уул, Сэлэнгэ, Төв аймгийн зарим сумдын зорилтот бүлгийн (малчид, мал бүхий иргэд, малын дунд өвчлөл бүртгэгдсэн өрх, голын ойролцоо нутаглаж буй өрх) хүн амын дунд мэдлэг, эрсдэлт хүчин зүйлийг тогтоох асуумж судалгаа 200 хүнээс авч, эмнэл зүйн үзлэг, хэвлийн эхо 200 (хэт авиан шинжилгээ), захын судаснаас цусны 200 сорьц цуглуулан лабораторийн шинжилгээ хийж ажиллалаа.

Хэвлийн хэт

авиан

шинжилгээгээр

☐ Элэгний уйланхай –1


☐ Элэгний сорвижил–2

☐ Төрөлхийн 1 бөөр олон уйланхайт диспластик өөрчлөлттэй –1

☐ Бөөрний энгийн уйланхайтай – 5 тохиолдол тус тус тодорхойлогдсон.



Судалгаанд дескриптив судалгааны агшингийн загвар ашиглан 5 аймгийн 7 сумын 5–88 насны 200 хүнийг хамруулав. Зорилтот бүлгийн хүн амын дунд бэтэг, токсоплазмоз, фасциолиаз өвчний (Taeniidae овгийн *Echinococcus* (эхинококк), *Toxoplasma gondii*, *Fasciola* spp үүсгэгч) урьдчилан боловсруулсан асуумжаар мэдлэгийг тогтоосон. Асуумж судалгаагаар анзаарагддаггүй халдварын мэдлэгийн түвшин хангалтгүй үнэлэгдсэн.



НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНД, ТАНДАЛТ, ШУУРХАЙ УДИРДЛАГЫН
АЛБА